



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль

Хөтөлбөрийн нэр: Урлаг судлал

Индекс: D021801

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Гантулга

ИЗОУИС-ийн харьяа Дүрслэх Урлаг Дизайн Технологийн Дээд Сургуулийн захирал

Гишүүд: Ш.Эрдэнэцэцэг

СУИС-ийн Соёлын Сургуулийн захирал

Д.Уранчимэг

Дүрслэх Урлагийн Академи дээд сургуулийн захирал

Он сар өдөр: 2022.06.14

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АНУ -Америкийн Нэгдсэн Улс
БНбд- Барилгын норм ба дүрэм
БМИҮЗ- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БС- Бизнесийн Сургууль
БСХХ- Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо
БСШУСЯ- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БСШУЯ- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХЦСТ- Багшийн хөгжил, цахим сургалтын төв
БЦ- Багц цаг
БШУ- Боловсрол шинжлэх ухаан
БШУС- Боловсрол, шинжлэх ухааны сайд
ДООБ- Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага
ЕБС- Ерөнхий боловсролын сургууль
ЕСХХ- Ерөнхий суурийн хөтөлбөрийн хороо
ЗХШҮА- Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний алба
ИДСК- Их дээд сургууль коллеж
МИ- Магадлан итгэмжлэл
МТХ- Мэдээлэл технологийн хэлтэс
МУ- Монгол улс
МУБИС- Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУИС- Монгол Улсын Их Сургууль
СУИС- Соёл урлагийн их сургууль
ДУА- Дүрслэх урлагийн академи
НҮБ- Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОК- Оюутан конгресс
ОТХ- Оюутан төгсөгчийн хэлтэс
ОУЭШХ- Олон улсын эрдэм шинжилгээний хурал
ӨҮТ- Өөрийн үнэлгээний тайлан
СА- Сургалтын алба
СБД- Сүхбаатар дүүрэг
СДХХ- Салбар дундын хөтөлбөрийн хороо
СиСи- Сургалт, мэдээллийн СиСи систем
СНА- Сургалтын нэгдсэн алба
СНГ- Сургалтын нэгдсэн газар
ТББ- Төрийн бус байгууллага
ТҮЦ -Түргэн үйлчилгээний цэг (машин)
ТХХ -Тэнхимийн хөтөлбөрийн хороо
УЗУСТ- Утга зохиол, урлаг судлалын тэнхим
ХЕХ- Хөтөлбөрийн ерөнхий хороо
ХУС -Хүмүүнлэгийн ухааны салбар
ХЧБХ- Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс
ХЧБХ- Хөтөлбөр, чанар баталгаажуулалтын алба
ЦЕГ- Цагдаагийн ерөнхий газар
ШУС- Шинжлэх ухааны сургууль
ЭБХ- Элсэлт бүртгэлийн хэлтэс
ЭЕШ- Элсэлтийн ерөнхий шалгалт
ЭШБ- Эрдэм шинжилгээний бичиг

Гадаад үгс

CDIO- Conceive Design Implement Operate

JCR- Импакт фактор бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүл

PDS -Бүтээлийн хулгайгаас урьдчилан сэргийлэх, бүтээлийн хулгайг илрүүлэх

SiSi- МУИС-ийн Сиси сургалтын мэдээллийн систем

КОНА -Номын сангийн автоматжуулсан программ

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол Улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль School of Arts and Science, National University of Mongolia	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Урлаг судлал Art studies	
Индекс	D021801	
Шинжээчид	Б.Гантулга- ИЗОУИС-ийн харъяа Дүрслэх Урлаг Дизайн Технологийн Дээд Сургуулийн захирал Ш.Эрдэнэцэцэг- СУИС-ийн Соёлын Сургуулийн захирал Д.Уранчимэг- Дүрслэх Урлагийн Академи дээд сургуулийн захирал	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2022.06.06	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах
		Сургууль, номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцах
		Оюутнуудтай уулзах
		Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
	2022.06.07	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах
		Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
		Багш нартай уулзах
Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах		
	Шинжээчдийн багийн уулзалт	
	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийн талаар байгууллагад танилцуулна.	
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

МУИС-ийн урлаг судлалын хөтөлбөр 1992 онд Ардын урлаг судлалын тэнхим нэртэйгээр байгуулагдаж, үндэсний урлаг судлаач бэлтгэж эхэлсэн цагаас өнөөг хүртэл 30 жил тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.

2014 оноос Утга зохиол судлал хөтөлбөртэй нэгдэн Утга зохиол, урлаг судлалын тэнхим болсон. Тус хөтөлбөр нь 25 төгсөлт хийсэн бөгөөд 294 бакалавр, 95 магистр, 10 доктор төгсгөсөн байна. Урлаг судлал хөтөлбөр нь үндэсний язгуур урлаг судлаач, мэргэжилтэн, урлаг судлаач-багш бэлтгэсэн ууган мэргэжил-хөтөлбөр болно. Үндэсний язгуур урлагийн оршихуй-эртний түүх, угсаатны зүй, хэл соёл, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг олон салбар ухаантай холбогддог, мэдлэгийн цогц бүрэлдэхүүн хэсэг юм. Урлаг судлалын мэргэжлийн ангиудыг төгсөгчид нь боловсрол шинжлэх ухаан, мэргэжлийн урлагийн байгууллага, соёл урлагийн салбарт эрэлттэй байна. Үүнд: Монгол судлалын салбар, бүх мэргэжлийн урлагийн байгууллага, тухайн шинжлэх ухааны салбарт судалгаа шинжилгээний ажил хийх чадварлаг мэргэжилтэн бэлтгэх, үндэсний урлаг соёлын цогцыг тээсэн язгуур ухаанууд ба дэлхийн урлаг, соёлын мэдлэгийг хамт эзэмшдэг салбар юм.

Хөдөлмөрийн зах зээлд ажлын байрны эрэлт хэрэгцээ үргэлж өсөн нэмэгдэж байна. Үүнд БШУЯ, ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд (Соёл, урлаг судлалын хүрээлэн, Түүхийн хүрээлэн), Соёлын яам, түүний харьяа мэргэжлийн соёл, урлагийн байгууллага (театр, музей, галерей, чуулга, телевиз, радио), их дээд сургуулиуд (Монгол улсын их сургууль, Соёл, урлагийн их сургууль, Шинжлэх ухаан, техникийн их сургууль, Монгол Улсын Консерватори, Кино урлагийн дээд сургууль, Дүрслэх урлагийн академи)-д ажиллан урлагийн онол, түүхийг тайлбарлан таниулах, ардын болон дэлхий дахины урлагийг судлах, бодлого боловсруулах чиглэлээр ажиллаж байна.

БШУ-ны сайдын 2014.03.13-ны өдрийн А/78 тоот “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” тушаалаар ЮНЕСКО-оос баталсан бакалаврын хөтөлбөр индексийн дагуу олон улсын ангилалд нийцүүлэн шинэчилж, мэргэжлийн чиглэлийг “Урлаг судлал”, индексийг D021801 гэж шинэчлэн батлав. Шинэчилсэн мэргэжлийн чиглэл, индексийг 2014- 2015 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж ажилласан байна.

БШУС-ын 2017.06.29-ний өдрийн А/52 тоот тушаал, “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, 2020.07.01-ний өдрийн А/308 тоот тушаал, “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, БШУ-ны сайдын 2014.04.28-ны өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-д нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг ерөнхий болон мэргэжлийн суурь хичээлийг 45 багц цаг, мэргэжлийн заавал, сонгох хичээлийг 60 багц цаг, чөлөөт сонголтын 15 багц цагийн хичээлээс бүрдсэн байхаар боловсруулсан.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Монгол Улсын нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв хандлагад нийцүүлэн боловсруулсан.
- Сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд судалгаа хийж, эрэлтэд нийцсэн нийлүүлэлт хийх боломжийг бүрдүүлсэн.
- Хөтөлбөрийн давуу болон сул талаа тодорхойлж, цаашид сургалтын хөтөлбөрийг сайжруулах гарц, ажлын төлөвлөгөө хийсэн.
- Тухайн ажлын төлөвлөгөө, гарцаа тодорхойлохын тулд гадаадын 6 их сургууль, дотоодын 1 их сургуулийн хөтөлбөрийг судалж, давуу болон сул талаа тодорхойлсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөдөлмөрийн зах зээл, сонирхогч талууд, хүний нөөцийн асуудлыг анхаарах хэрэгтэй.
- Соёл, урлагийн салбарын эрэлт хэрэгцээнд тулгуурлаж мэргэжилтэн бэлтгэх зах зээл дэх хүний нөөцийн хувь хэмжээ ямар байгааг харгалзах.
- Хөтөлбөрт практикт суурилсан хичээлийн агуулга дутуу байна.
- Мэргэжлийн багшлах боловсон хүчин бага байна.
- Сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт хийх шаардлагатай.

Зөвлөмж:

- Төгсөгчид болон суралцагчидтай хийсэн ярилцлагаас үзэхэд: Мэргэжлийн заавал судлах хичээлд сонгон судлах хичээлээс оруулах, кредитийг нэмэх
- Тайз, дэлгэц, Музей судлал, Соёлын менежмент, Соёлын өвийн чиглэлээр Төрийн өмчийн их сургуулийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд СУИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн багш нараар заалгаж, харилцан кредит тооцох.
- Сургалтын төлөвлөгөөний сонгон суралцах хэсгийн соёл, урлагийн чиглэлийн зарим хичээлийг мэргэжлийн суурьт оруулах, дадлагын тоог нэмэгдүүлэх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загварын шаардлагад нийцүүлэн боловсруулсан.
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилтод нийцүүлсэн.
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн баримт материалыг хэвлэмэл болон МУИС-ийн веб сайт, SISI сургалт, удирдлага, мэдээллийн системд оруулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн сургалтын журамд нийцүүлэн мэргэжлийн хөтөлбөрөөр төгсөгчдийн компетенц /мэдлэг, чадвар, хандлага/, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлж, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг боловсруулсан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилго хэтэрхий өндөр шаардлагатай. Урлаг судлаач, Соёлын ажилтан бол тусдаа 2 мэргэжил гэдгийг анхаарах хэрэгтэй.
- Сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хөтөлбөрийг нийцүүлэх шаардлагатай.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг оролцогч болон сонирхогч талууд, төгсөгчид, суралцагчдын санал, хүсэлтийг авч өөрчлөх.
- Хөтөлбөр нь үндэсний хэмжээнд баримталж буй бодлоготой хэрхэн уялдаж байгааг тодруулах, “соёл, урлагийн байгууллагад эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх” “Урлаг судлал” хөтөлбөрийн зорилгод нийцүүлэх.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Батлагдсан хөтөлбөртэй
- Хурлын тэмдэглэл тухай бүрд хийгдсэн
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/ -ыг хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу 16 хууль, журам, заавар зөвлөмжийг тусгаж хөтөлбөрийг боловсруулсан.
Бүрэлдэхүүн сургуулийн болон МУИС-ийн ерөнхий хороогоор хөтөлбөрөө хэлэлцүүлж батлуулдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн харьцуулалтад гадаадын 7 их сургуулийн хөтөлбөрийг судалж үзсэн боловч, одоогийн хөтөлбөрт тусгагдаагүй.
- 1992 оноос 12 удаа шинэчлэхэд олон хичээл хасагдсан.

Зөвлөмж:

- 7 их сургуулийн хөтөлбөрийг судалсан үр дүнг “Урлаг судлал” хөтөлбөртөө тусгахдаа шууд хуулбарлан буулгахгүй байхад анхаарах.
- 12 удаа шинэчлэхэд хасагдсан урлаг судлалын суурь болох зарим хичээлийг нэмэх.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матрицыг оновчтой тодорхойлсон.

Удирдлагын мэдээллийн системээр дамжуулан хичээл, багш, хичээлийн цагийн сонголтыг хийдэг.

Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд шинжилгээ, сайжруулалт хийсэн.

Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/-ийг оновчтой тодорхойлон, ашигладаг.

Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаатай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн индекс, суралцахуйн үр дүнгийн матриц тодорхой, ойлгомжтой.
- Ерөнхий суурийн хичээлүүдийг оюутны сонирхлын дагуу сонгон судлах боломж бүрдүүлсэн.
- Үйлдвэрлэлийн дадлагыг төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшсэн.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, мэргэжлийн заавал болон сонгон судлах хичээлийн уялдаа холбоог оновчтой тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- Дадлагын тоо, багц цагийг нэмэгдүүлэх: 1-р курсын төгсгөлд танилцах дадлага, 2-р курсын зун хээрийн дадлага, 3-р курст үйлдвэрлэлийн дадлага гэх мэтээр 6 кредитээс багагүй дадлага хийлгэх.
- Мэргэжлийн хичээлүүд дээр суралцагч багшаа сонгох сонголт боловсон хүчний нөөцөөс хамаарч хязгаарлагдмал байна. Суралцагч хэд хэдэн багшаас сонголт хийх боломжийг бүрдүүлэх.

- Сургалтын төлөвлөгөөний мэргэжлийн сонгонд байгаа зарим хичээлүүдийг заавал судлах хичээлээрээ оруулах. Сонгон судлах хичээлүүдийн кр цаг, нэр төрлийг нэмэгдүүлэх, оюутанд сонгосон чиглэлээрээ мэргэших боломжийг бүрдүүлэх.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн агуулгын хувьд АНУ, Их Британи улсын их сургуулиудтай харьцуулахаас илүүтэй хөрш орнуудын их сургуулийн сургалтын хөтөлбөр, онцлогоос судлах, туршин хэрэгжүүлэх нь илүү ач холбогдолтой, үр дүнтэй юм.
- Танилцах дадлагыг 1-р курсээс эхлэн соёл урлагийн байгууллагуудад хийлгэвэл оюутнууд мэргэших чиглэлээ хурдан олж авах давуу тал харагдаж байна.
- Төрийн өмчийн 6 их сургуулийн хамтын хөтөлбөрийн программ хэрэгжих болсонтой уялдуулан бусад сургуулиудтай нэгдсэн хөтөлбөр, сурах бичиг хийх, нэгдсэн дадлагын баз байгуулах зэрэг олон талт ажлуудыг зохион байгуулах боломж харагдаж байна.
- МУИС нь Урлаг судлал хос хөтөлбөртэй боловч түүний маркетинг, зар сурталчилгаа явуулж мэргэжлээ сайн сурталчлах хэрэгтэй байна.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үр дүнд суурилсан сургалтын аргазүйг хэрэгжүүлж эхэлсэн.
- Их сургуулийн хэмжээнд суралцагчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын шинэлэг аргуудыг хэрэгжүүлж ажилладаг.

Анхаарах асуудал:

- Сургалтад дэвшилтэт технологи, шинэлэг аргазүй ашиглах.

Зөвлөмж:

- Зочин багш нарыг ажиллуулах эрэлт хэрэгцээ байгаа ба соёл урлагийн зах зээлд нэрд гарч байгаа уран бүтээлчдийг урьж, мастер класс хийлгэх зэрэг ажил явуулах хэрэгтэй байна.
- Оюутны клубуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх. Төгсөх ангийн оюутнууд үйлдвэрийн дадлагад гарахдаа нэг ч урлагийн үзмэр үзээгүй оюутнууд байдаг тухай ажил олгогчид ярьж байсан бөгөөд үүнийг улирал тутам оюутнууд оюутны зөвлөл, клубтэй хамтран соёл урлагийн үзвэр үзэх, үзсэн үзвэр дээрээ дүн шинжилгээ хийж шүүмж бичих, хэлэлцүүлэг хийх гэх мэт хичээлийн бус цагаар судалгааны ажил хийж, үүнийгээ бас үнэлүүлэх тогтолцоог бий болгох боломжтой.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт, чанар г.м/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн хичээлийн үнэлгээний Рубрик боловсруулж эхэлсэн.
- Явц, төгсөлтийн шалгалтын үнэлгээний хэлбэр нь тодорхой, ойлгомжтой.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн амжилт, ахицын талаар тодорхой судалгаа, мэдээлэл дутмаг байна.

Зөвлөмж:

Суралцагчийн амжилт ахиц, мэргэшихээр сонирхолж, буй чиглэлийг тодорхойлох судалгааг тогтмол хийж, үр дүнгийн мөрөөр ажил хэрэгжүүлэх.

Багш бүр үнэлгээний Рубрик боловсруулж хэрэгжүүлэх, энэ ажлыг эрчимжүүлэх.

Мэргэжлийн хичээлүүдийн бие даалтын ажлыг илүү бүтээлч, судлаач хандлага, чадварыг нэмэгдүүлсэн ажлууд хийлгэх.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан.
- Сургууль дээр ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдээллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл.
- Хөтөлбөрийн талаар багш нар, төгссөн оюутнууд, одоо сурч байгаа оюутнуудтай хийсэн уулзалт тэмдэглэлүүд.

- Багш нартай уулзаж хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй ярилцсан тэмдэглэл.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалт, судалгаа явуулах анги танхим, шаардлагатай тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори болон багшийн ажиллах орчин хангагдсан байна.
- Төрөөс болон олон улсын байгууллагаас тодорхой хэмжээний санхүүжилт хийгддэг байна.
- Анги танхим бүр интернэтэд холбогдсон.
- Урлагийн галерей байгуулах төсөл боловсруулж санал хүргүүлсэн.

Анхаарах асуудал:

- МУИС-ийн барилга байгууламжийн чанар стандарт, эрүүл ахуйн цэврийн шаардлага хангасан байдлын хүснэгт тодорхойлолтоор барилгын насжилт өндөр тул жил бүр байнгын засвар үйлчилгээ шаарддаг.
- Хичээл сургалтын чиглэлээр ашигладаг боловч мэргэжлийн бүрэн тоноглогдсон анги байхгүй байна.
- Хичээлийн 2-р байранд хөгжлийн онцлогтой оюутанд зориулсан хаалганы босгонд пандус, бусад шаардлагатай зүйлс байхгүй.
- Хичээлийн 2-р байранд багш, оюутанд үйлчлэх нэгдсэн төв байхгүй.

Зөвлөмж:

- Суралцагчийн цахим орчин бие даан болон багаар ажиллах мэргэжлийн орчинг бий болгох
- Сургалтын орчны талаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг үндэслэн засаж, сайжруулах арга хэмжээ авч байх

Шаардлага:

- Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагыг хангасан мэргэжлийн анги, урлан байгуулж, сургалт судалгаа хийх багаж тоног төхөөрөмжтэй болгох.
- Хичээлийн 2-р байранд хөгжлийн онцлогтой оюутанд зориулсан хаалганы босгонд пандус, бусад шаардлагатай зүйлст бүтээн байгуулалтын ажил явуулах.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан.
- Сургууль дээр ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдээллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл.
- Хөтөлбөрийн талаар багш нар, төгссөн оюутнууд, одоо сурч байгаа оюутнуудтай хийсэн уулзалт тэмдэглэлүүд.
- Багш нартай уулзаж хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй ярилцсан тэмдэглэл.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Цахим орчин бие даан болон багаар ажиллах орчны хангалтыг sisi, teams платформд хийдэг боловч амьд харилцаа үүсэх магадлал багатай тул фейсбүүк орчинд хаалттай группээр харьцдаг.
- Цахим сургалтаа MS Teams-ээр зохион байгуулдаг.
- Сургалт, судалгаа явуулах курс болгон өөрийн анги танхимтай. Хичээлийн 2-р байрны 322 тоотын компьютерын лабораторийг бүх курс бүрэн ашигладаг нь шаардлагад нийцэж байна /Компьютерын үзүүлэлт нь I5/
- Багш болгон суурин компьютерээр хангагдсан бас хэвлэгч төхөөрөмжтэй.
- Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг.
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материалыг бүх багш нар боловсруулан хэрэглээнд нэвтрүүлсэн.

Анхаарах асуудал:

- Багш нарын боловсруулсан цахим хичээл бүрэн хийгдэж туршигдаагүй.
- Цахим сурах бичиг, сургалтын мэдээллийн хэрэглэгдэхүүний хүртээмж бага.
- Багш нарын хичээлийн сурах бичиг байхгүй.

Зөвлөмж:

- Оюутан зайнаас суралцах боломжийг хангах, цахим сурах бичиг, сургалтын мэдээллийн хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулах.
- Багш нарын боловсруулсан цахим хичээлийг бүрэн хийж дуусган туршиж, сургалтад ашиглах.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан.
- Сургууль дээр ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдээллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл.
- Хөтөлбөрийн талаар багш нар, төгссөн оюутнууд, одоо сурч байгаа оюутнуудтай хийсэн уулзалт тэмдэглэлүүд.
- Багш нартай уулзаж хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй ярилцсан тэмдэглэл.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн сурах бичиг, гарын авлага боловсруулан, шинээр хэрэгцээ хангамжийг тооцоолон “Урлагийн боловсрол”, “Урлагийн онол, түүхийн удиртгал”, “Соёл судлал” хичээлийн сурах бичгийг боловсруулан бэлэн болгосон.
- Сургууль, тэнхимээс хөтөлбөр дагасан ном, сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл гэсэн багш нарын бүтээлийн жагсаалтыг тайландаа тусгасан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр дагасан ном, сурах бичиг, гарын авлагууд ихэвчлэн гадаад хэл дээр байдаг.
- Багш нарын хичээлийн сурах бичиг хэвлэгдээгүй.
- Мэргэжлийн эрдэм шинжилгээний өгүүлэл, сэтгүүл ховор.

Зөвлөмж:

- Хичээлийн сурах бичиг, гарын авлага боловсруулан, шинээр хэрэгцээ хангамжийг сургуулийн зүгээс нэмэгдүүлэхэд анхаарах.
- Хөтөлбөр дагасан ном, сурах бичиг, гарын авлагууд ихэвчлэн гадаад хэл дээр байгаа тул өөрийн эх хэл дээр хөрвүүлэх ажлыг зохион байгуулах.
- Оюутан зайнаас суралцах боломжийг хангах, цахим сурах бичиг, сургалтын мэдээллийн хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулах.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж, хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичиг, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал, гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн дэд хорооны баримт бичгүүдийг сайн бүрдүүлж хэвшсэн.

- Хөтөлбөрт ирсэн санал, гомдлыг тухай бүрд нь шуурхай шийдвэрлэдэг.
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал хангалттай.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн оролцогч талуудаас авсан судалгаа, санал, санаачлагад анализ хийж, хөтөлбөрийг сайжруулалт, шинэчлэлтэд тусгасан талаар мэдээлэл дутмаг байна.

Зөвлөмж:

- “Урлаг судлал” хөтөлбөрт онолын хичээл дийлэнх хувийг эзэлж байна. Иймээс онол, түүх-60%, урлагийн төрөл зүйл-40% тай байхаар зохион байгуулах.
- Мэргэжлийн багш бэлтгэх, зочин профессор урих.
- “Урлаг судлал”-ын тусдаа тэнхимтэй болох боломжийг эрэлхийлэх.
- Хөтөлбөрийн маркетингийн үйл ажиллагааг идэвхжүүлэх.
- Оюутан солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
- Ном сурах бичгийн хангалтад анхаарах /Оюутны санал/

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм, журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шинжлэх ухааны сургуулийн хөтөлбөрийн хороо 15 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн хөтөлбөрийн хороо нь 7 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг.
- Одоогийн байдлаар ХБНГУ-тай “Урлаг судлал” хөтөлбөрөөр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэ гэрээнд багш, суралцагч солилцох талаар орсон байна.
- Урлагийн байгууллагад дадлага хийдэг.
- SIS системийн эргэх холбоог сайн ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэх.
- Нийгэмд үзүүлэх үйлчилгээний хэлбэр, агуулгыг тодорхой болгох.

Зөвлөмж:

- Урлагийн байгуулагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, суралцагсдыг танилцах болон үйлдвэрлэлийн дадлагыг чанартай хийх.
- Урлагийн төрөл зүйлээр дагнасан, нийгэмд чиглэсэн соёлын ажил зохион байгуулах.
- Ажил олгогчдын саналыг хөтөлбөрийн шинэчлэлд тусгах.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтыг тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шинжлэх ухааны сургууль болон, урлаг судлал хөтөлбөрийн орлого, зарлагыг тооцож, ашигтай ажиллаж байгаа дүн гарсан.

Анхаарах асуудал:

- 2020 онд хөтөлбөрийн орлогын 91,6% нь багш, ажилтны цалин хөлсөнд олгогдсон.
- 0,78% хичээл, практикийн зардал байна.

Зөвлөмж:

- Төсвийн гүйцэтгэлийн тэнцвэрт байдлыг хангах.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалтад багш, ажилтны цалин хөлсийг 60-70% байхаар тооцох.
- Элсэгчдийн тоог нэмэгдүүлэх.
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлыг тооцох.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжил сурталчлах өдөрлөг, цуврал уулзалт, ярилцлага зохион байгуулдаг.
- Урлагийн байгууллагуудтай хамтарч ажилладаг.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн маркетинг зорилтот бүлэгт хүрч байгаа эсэхэд анализ хийх
- Төгсөгчдийн хөрвөх боломжид анхаарч, соёлын болон урлагийн чиглэлийн сургуулиудтай хамтарч ажиллах /Төрийн өмчийн их сургуулиудын хооронд/

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном, товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн цахим хуудас, элсэлтийн цахим хуудас, бүртгэлийн нэгдсэн систем, ахисан түвшний сургуулийн цахим хуудас, Шинжлэх ухааны сургуулийн цахим хуудас, тэнхимийн пэйж хуудас, төгсөгчдийн нэгдсэн групп зэргээр хангалттай мэдээллийг нээлттэй хүргэдэг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд анхаарах.

Зөвлөмж:

- Авыастай элсэгчдийг элсүүлдэг байх.
- Мэргэжлийн сэтгүүл гаргах.
- Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээ нэвтрүүлэх.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн захирлын 2021.12.02-ны А/361 тоот тушаалаар МУИС-д хичээл дүйцүүлэх журам баталсан.
- Өөрийн үнэлгээний тайлан.
- Сургууль дээр ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдээллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл.

- Хөтөлбөрийн талаар багш нар, төгссөн оюутнууд, одоо сурч байгаа оюутнуудтай хийсэн уулзалт тэмдэглэлүүд.
- Багш нартай уулзаж, хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй ярилцсан тэмдэглэл.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн захирлын 2016.07.08-ны А/199 тушаалаар Монгол улсад Кембрижийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй 6 сургуулийн төгсөгчдийн А болон АS түвшинд судалсан хичээлүүдийг МУИС-ийн ерөнхий суурь хичээлтэй нь дүйцүүлдэг онцлогтой.

Анхаарах асуудал:

- Элсэгч, суралцагчид хүсэл сонирхлоороо энэ мэргэжлийг сонгон орж ирэхэд 1-р түвшинд ерөнхий эрдмийн хичээл сургалтад байгалийн шинжлэлийн хичээл буюу огт хамааралгүй хичээл үздэг нь мэргэжлийн чиг баримжаа алдагддаг байна.
- Ихэнх элсэгчид энэ мэргэжлийн чиглэлээр бүрэн ойлголттой орж ирээгүйгээс үүдэн 1-р курсийн хичээл сургалтад тэнхимийн зүгээс анхаарах нь бага байна. 2017 оны хурлын тэмдэглэлээс Д.Сайнбилэг, Б.Отгонтөгс г.м хүмүүсээс асуудал, саналууд гарч байсан.
- Элсэн суралцагчдыг тусгайлан сонгон шалгаруулах шалгуур байхгүй.
- Багш болон суралцагчид мэргэжлээрээ 3 жил сурч байна гэсэн ойлголттой.

Зөвлөмж:

- Сургалтын үйл ажиллагаанд оролцогч оюутны тоо бага байгаа нь салбарын хөгжлөөс шалтгаалж байгаа хэдий ч энэ мэргэжлийн талаар зөв зүйтэй ойлголт өгөх, сурталчлах тал дээр сургуулийн зүгээс анхаарч ажиллах.
- 1-р курсийн хичээл сургалтад тэнхимийн зүгээс анхаарч, оюутнуудад мэргэжлийн зөвлөлгөө өгөх, арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулах.
- Элсэн суралцагчдыг тусгайлан сонгон шалгаруулах шалгуурыг боловсруулан нэвтрүүлэх.

Шаардлага:

- Хөтөлбөрийг сонгосон суралцагчдад 1-р курст ордог ерөнхий эрдмийн хичээл сургалтад анхаарч огт хамааралгүй хичээлийн оронд, тэнхимээс судалгаа аван хамаарал бүхий хичээл оруулах, мөн элсэгчдэд тусгайлан сонгон шалгаруулах шалгуурыг боловсруулан нэвтрүүлэн ажил болгох.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан.
- Сургууль дээр ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдээллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл.
- Хөтөлбөрийн талаар багш нар, төгссөн оюутнууд, одоо сурч байгаа оюутнуудтай хийсэн уулзалт тэмдэглэлүүд.

- Багш нартай уулзаж хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй ярилцсан тэмдэглэл.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдад зөвлөн туслах тал дээр сайн. Олон төрлийн клуб байгуулж, оюутан суралцагчдын дунд уулзалт танилцуулга хийж, хамрагдсан оюутны тоо, судалгаа гаргаж байгаа нь зөв ажил болжээ.
- Оюутнуудын суралцах идэвх, бүтээлч санаачлагыг өрнүүлэх тал дээр оюутны өөрийн удирдлагын байгууллага болон клубуудыг ажиллуулдаг байна.

Анхаарах асуудал:

